



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/644

Есөнбулаг

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Улсын Их Хурлын "Хүнсний хангамж, аюулгүй байдлын тухай" 2022 оны 36 дугаар тогтоол, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4 дүгээр бүлгийн 4.1.4 дэх зорилтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүнсний аюулгүй байдлын хүрээнд баталгаатай эрүүл хүнсээр иргэдийг хангаж, малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор "Хүргэлт-V" нэгдсэн арга хэмжээг 2024 оны 12 дугаар сарын 07-10-ны өдрүүдийн хооронд Улаанбаатар хотод зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Алтангэрэл (Аймгийн Засаг даргын орлогч)
Л.Хаш-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)
Д.Төмөрбаатар (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга)
Б.Бүрэнбаясах (Аймгийн Мал эмнэлгийн газрын дарга)
Н.Мэндбаяр (Аймгийн Цагдаагийн газрын дарга)
Ё.Нарангарав (Аймгийн "Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв" УТҮГ-ын захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Нарийн бичгийн дарга: Т.Сүхбаатар (Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

2.Тус арга хэмжээг зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг гаргаж, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэн, дүнг Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (М.Алтангэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ